



## ШИНЭ НОМЫН МЭДЭЭ НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ



2008/11,12 №06(09)



Шинжлэх Ухаан Технологийн  
Их Сургууль

# **Шинэ номын мэдээ Номын сангийн мэдээлэл**

Улаанбаатар  
2008 он

!

2008/11,12 №06(09)

Редактор: Ч.Гульнар (Ph.D)  
Эмхэтгэсэн: Ч.Хишигсүрэн (Магистр)  
Ж.Баатарсүрэн  
О.Ариунжаргал

Манай хаяг:  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу, 8-р хороо ШУТИС-ийн 1-р байр  
Утас: 314029, 324590-1026,1027,1034  
Майл: [library@must.edu.mn](mailto:library@must.edu.mn)

**Энэ дугаарт**

2008 оны фонд бүрдүүлэлт	...2
2008 оны 11, 12 сарын шинэ номын мэдээ	...3-41
Солонгосын Чонбукийн сургуулийн номын сангийн төлөөлөгчид ШУТИС-д зочиллоо	...42
ОХУ-д сургалтанд хамрагдав	...43
Номын сэдэвчилсэн үзэсгэлэн гаргалаа	...43
Төсөл хэрэгжиж байна	...44
Солонгосын Их Сургуулиудын е-номын сангийн үйл ажиллагаатай танилцав	...45-47
Төв номын сангийн үйлчилгээ	...48-49

Төвлөрсөн номын сан

**Төвлөрсөн номын сан - Фонд бүрдүүлэлт**

Төвлөрсөн номын сан 2008 онд 91 сая төгрөгийн 1000 гаруй төрлийн 12 мянга орчим ном, сурах бичиг, гарын авлагаар фондоо баяжуулсан болно. Энэ нь нийт ном, сурах бичиг авах төсвийн 60 гаруй хувийг эзлэж байна.

Номын фондын баяжилт сайжирч, нэг оюутанд ноогдох мэргэжлийн болон ерөнхий эрдмийн номын хангамж нэмэгдсээр байна.

**ШУТИС-ийн Төв номын сангийн 2008 онд  
бүрэлдэхүүн сургуулиудын номын төвлөрлийн тооцоо**

2008-12-15ны байдлаар

№	Бүрэлдэхүүн сургуулийн нэрс	Ном, сурах бичгийн нийт зардал 1,5% /мян.төг/	Сургуулиудиа төв номын санд ном, сурах бичиг авах зардал (60%) /мян.төг/	Сургуулиудын 60% ном, сурах бичиг авсан байдал /төг/	60%ийн биелэлт	Үлдэгдэл тооцоо /мян.төг/
	<b>Төв номын сан 40%</b>		<b>30900.0</b>	<b>23109701</b>	<b>74.7%</b>	<b>7 790 299</b>
1	БИАС	20000.0	12000.0	6956700	57.9%	5043.3
2	УУИС	8000.0	4800.0	5774500	100%	
3	ЭХИС	15000.0	9000.0	4935400	54.8%	4064.6
4	ГГТС	7400.0	4440.0	2002500	45.1%	2437.5
5	ХБТС	10500.0	6300.0	1800000	28.5%	4500.0
6	МТС	3500.0	2100.0	317000	15.0%	1783.0
7	МС	4500.0	2700.0	890025	32.9%	1809.9
8	ХБС	5350.0	3210.0	475220	14.8%	2734.7
9	ХУС	3000.0	1800.0	939500	52.1%	860.5
10	КТМС	16800.0		9640500	63.7%	6509.5
11	ҮТДС	12000.0		5830300	53.9%	6169.7
12	ХМТС	15000.0		11166612	82.7%	3483.3
13	МИС	11000.0		7268916	73.4%	3336.0
14	ДТС	18600.0		8559664	46.0%	10040.3
<b>Бүрэлдэхүүн сургуулиуд багш нарынхаа хэвлүүлсэн бүтээлээс журмын дагуу төв номын санд шилжүүлсэн байдал</b>						
	КТМС		1680.0	650000	38.6%	1030.0
	ҮТДС		1200.0	0	0%	1200.0
	ХМТС		1500.0	350000	23.3%	1150.0
	МИС		1100.0	395000	35.9%	705.0
	ДТС		1860.0	0	0%	
	<b>НИЙТ :</b>	<b>150.650.000</b>		<b>91.061.538</b>	<b>60.4%</b>	<b>59588462 төг</b>

**2008 оны 11, 12 сард Төв номын сан нийт 25 төрлийн 159 ширхэг  
ном, сурах бичиг авсан**


**Техник, технологийн чиглэлээр:**



**Ганбаатар Н.  
Цөмийн идэвхжилийн анализ / Хян.  
Ц.Амартайван.- УБ., 2008.- 188х.- ISBN 978-  
99929-53-70-5 Нийт- 5ш**


Гарын авлага нь 3 бүлэг, хавсралтаас тогтсон бөгөөд  
Нэгдүгээрт бүлэгт: Цөмийн идэвхжилийн анализын физик үндэс, анализын төрөл, анализ хийх арга зүйн тухай  
Хоёрдугаар бүлэгт: Цөмийн идэвхжилийн анализын алдааны эх үүсвэрүүд, тэдгээрийг арилгах, сэргийлэх, багасгах, тооцох аргуудын тухай  
Гуравдугаар бүлэгт: Цөмийн идэвхжилийн анализад хэрэглэгддэг нейтроны болон гамма-цацрагийн үүсгүүр, багаж төхөөрөмжийн талаар дэлгэрэнгүй тусгасан байна.

**Болормаа Д.  
Microsoft Excel 2007: Өөрөө сурах  
бичиг / Хян. Э.Цогоо.- УБ.: Хаан принтинг,  
2008.- 364х.- ISBN 978-99929-55-35-X  
Нийт-1ш**



Зохиогч энэхүү гарын авлагадаа компьютерийн хамгийн өргөн хэрэглэгддэг электрон хүснэгтийн MS Excel 2007 програмын шинэчлэгдсэн интерфэйсийг танилцуулж, энэ програмыг хэрэглэсэн тоо, текстэн мэдээллийг хүснэгт хэлбэрээр зохион байгуулж боловсруулах, задлан шинжлэх аргачлалыг танилцуулсан байна. Бизнес жишээн дээр Excel-ийн командуудыг тайлбарлаж, тэдгээрийн англи нэр томъёонуудыг монгол хадмалтайгаар өгч, хийх үйлдлүүдийг алхам алхмаар зураг ашиглан дэлгэрэнгүй тайлбарласан байна. Түүнээс гадна хэрэглэгчдэд нийтлэг тохиолддог бэрхшээлүүдээс гарах арга зам, товч лавлахыг хавсаргажээ.

Төв номын сан-3ш . МИС-2ш . ХМТС-12ш



**Photoshop CS3: Цуврал 1 / Хян. О.Намнансүрэн; Орч. Ц.Дорнотуяа.- УБ., 2008.- 158х. Нийт-**


Тус ном нь Photoshop CS3 програмын үндсэн мэдлэг болон жишээ дасгалуудыг багтаасан цуврал хэлбэрийн ном юм. Номыг дагалдах CD-нд Photoshop CS3 програм Portable хэлбэрээрээ бичигдсэн бөгөөд мөн номын 2-р бүлэгт багтсан жишээ дасгалуудыг агуулсан болно.

Төв номын сан-10ш . ЭХИС-20ш

**Цагаан Х., Хуягдорж М.**

**Цахилгаан энергийн дамжуулалт хуваарилалт: Сурах бичиг /Ред. З.Цэрэндорж.- УБ.: Адмон, 2008.- 412х.**

Энэхүү сурах бичиг нь цахилгаан системийн горимын тооцоо, цахилгаан шугам сүлжээ, цахилгаан хүчдэл, дамжуулалт, агаарын шугам, цахилгаан хангамж, эрчим хүчний үйлдвэрлэл ба экологи, аюулгүй ажиллагааны үндэс, цахилгаан энергийн дамжуулалтын талаар дэлгэрэнгүй тусгасан эрчим хүчний бүх салбарын багш, оюутан магистр, доктрант, инженер техникийн ажилтнуудад зориулагдсан болно.



**Энхжаргал Х., Цэрэндолгор Ц.**

**Дулаан масс солилцооны процесс ба төхөөрөмж / Хян. Б.Намхайням.- УБ., 2008.- 465х. Нийт-25ш**

Уг сурах бичигт төрөл бүрийн дулаан солилцооны төхөөрөмж болон ширгээх, дистилляц ба ректификац хатаалгын төхөөрөмжид явагдах дулаан масс солилцооны процессын онолын үндэс, эдгээр төхөөрөмжийн үндсэн ба туслах тоноглолын хийц, дулааны ба хийцийн, гидравлик ба механик тооцоонуудыг тодорхой тусгасан болно. Энэхүү сурах бичгийг эрчим хүчний салбарын үйлдвэр болон бусад үйлдвэрлэлийн салбарын инженер, механикийн ажилтан эрчим хүчний мэргэжлийн бакалавр, магистрант, докторант оюутан ашиглахад зориулсан болно.

**Бямбагар Б.**

**Химийн 200 бодлого / Хянан тохиолд.**  
**А.Ганпүрэв .- УБ.: Бемби сан., 2008.-142х.-**  
**ISBN 978-99929-77-03-5. Нийт-20ш**



Ерөнхий боловсролын сургуулийн химийн гүнзгийрүүлсэн сургалттай ангийн сурагчид, их дээд сургуулийн бага курсийн оюутнууд, ЕБС болон коллежийн багш нар, ерөнхий мэдлэгийн ба гадаадын их дээд мургуульд элсэн уралдаант шалгалт өгөх сурагч, оюутнууд болон химийн олимпиадад бэлтгэгчдэд зориулав.

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан:**



**Нарантуяа Ж.**

**Англиар эссэ бичихэд суралцах нь:**  
**Гарын авлага / Хян. П.Увш.- УБ., 2008.- 115х.**  
**Нийт-2ш**

Англиар бичих үйл явцыг хялбаршуулан тайлбарлаж, холбогдох үндсэн ойлголт, нэр томъёог америкийн нэрт судлаач, эрдэмтдийн бүтээлд баримталсан онолын үндэслэлд тулгуурлан тодорхойлсон. Англи хэлийг гүнзгийрүүлэн судалж, улмаар бичиж сурахыг хичээж буй хүн бүрт зориулагдсан

**Лхагвасүрэн Б.**


**Түүвэр зоиол: Гурван боть.- УБ.,**  
**2008. Нийт-2 ком**

**Уянгын тойрог: Тэргүүн давтэр.-**  
**УБ.-228х.**

**Гашуун өвс: Дэд дэвтэр.- УБ.- 176х.**

**Цэцгийн манан: Гутгаар дэвтэр.-**  
**УБ.- 264х.**






**Монголын түүх / Ш.Лувсандорж,  
Ц.Цэрэн, Н.Галиймаа, ба бус. Ред.  
Ш.Лувсандорж, Н.Галиймаа.- УБ., 2008.-  
360х.- ISBN 978-99929-0-519-0 Нийт-40ш**

Энэхүү номонд орчлон ертөнц хийгээд хүний гарал үүсэл, дундад эртний үеийн Монгол орон Хүннү, Сяньби улсаас эхлэн Их Монгол Улс, XXI зуун хүртэлх Монгол орны соёл урлаг, зан заншил, сүсэг бишрэлийн талаар тусгаж өгсөн байна.

**Нямдаваа Д.  
Байхгүй юмгүй ном / Ред.  
А.Алимаа.- УБ., 2008.- 994х. Нийт-2ш**

Хөлөөс толгой хүртэл, газраас тэнгэр хүртэл, хязгааргүй одот орчлон, хамгийн энгийн арга засал дом, цэцэг чулуу бүгд орсон байна.



**Гонгоржав Г.  
Монголчуудын эрдэм ухааны  
уламжлал: Гурав дахь хэвлэл / Ред.  
С.Ишбалжир, С.Жамбалдорж.- УБ.: Сутра,  
2008.- 728х.- ISBN 978-99929-815-2-0  
Нийт-1ш**

Зохиогч номоо 3 бүлэгт хуваан уламжлалт мэдлэг ухаан гэсэн нэгдүгээр бүлэг математик, одон орон, оньсон техник, бодис зүй, газарзүй, уран барилга, анагаах ухаан...

Уламжлалт арга ухаан гэсэн хоёрдугаар бүлэгт мал маллагааны зүйл, ардын тариалан, ан гөрөөний зүйл, арьс нэхийн зүйл...

Уламжлалт идээн ундаан гэсэн гуравдугаар бүлэгт цагаан идээ, монгол цай, улаан идээ, дотор махан зоог, тураг махан зоог, ангийн махан зоог ногоон идээн... зэрэг монгол туургатны эрт үеэс уламжлал ирсэн арга ухаануудыг тусган харуулсан байна.



**Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар  
толь . Таван боть / Ред. Л.Болд . – УБ.: Бемби  
сан хэвлэх үйлдвэр.– 2008.**

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын хүрэлэнгээс гаргасан нийт 80-аад мянган толгой үг, 120 мянга орчим үг хэллэгийг багтаасан энэхүү 5 боть тайлбар толь нь монгол хэлний баялаг сан, орчин цагийн үгсийн сангийн үндсэн бүрэлдэхүүнийг багтаасан болно.

**Хэл, хэлний шинжлэл:**

**Баатар С., Энхбаян Ц.**

**Судалгааны түгээмэл ба ерөнхий  
 аргууд.- УБ., 2006.- 186х.-  
ISBN 99929-83-30-2 Нийт-2ш**

Эдийн засаг, менежмент, бизнесийн үйл ажиллагаатай холбогдсон судалгаа явуулах ерөнхий арга барил эзэмшихэд зориулагдсан ном юм. Мэдлэг, ШУ, судалгааны талаах ойлголтууд, ШУ танин мэдэхүйн философийн гол баримтлалууд, ШУ-ны арга зүй, судалгааны арга зүй дэх логик, оюуны дүгнэлт зэрэг агуулгыг хамарсан байна.



**Мөнхжаргал Д., Чимэгсанаа Т.  
Англи хэлний сурах бичиг / Хян.  
Д.Мөнхжаргал.- УБ., 2007.- 232х.-  
ISBN 978-99929-1-219-7 Нийт-3ш**

Сурах бичиг нл англи хэлийг анхан, дунд шатны төвшинд сурч буй янз бүрийн насны хүмүүст зориулагдсан тул энгийн, практик хэрэглээ ихтэй, цогц хэлбэрээр бичигдсэн. Мөн хоёр орны түүх, соёл, байгалийн тухай сэдвүүдийг англи, монгол хэлээр харьцуулан унших боломжийг олгож байгаа юм. Мөн англи-монгол 3000, монгол-англи 2000 гаруй үгсийг хамарсан товч толийг хавсаргасан байна.




**Speed-up Chinese, 1997.- ISBN 7-301-03260-9 Нийт-2ш**

Ном нь хятад хэлний анхан болон дунд шатны хэрэглэгчдэд зориулагдсан ба яриа ба бичих дүрмийг англи хадмалтайгаар оруулсан байна.

**Мөнхбаатар С., Болор Б.**

**Учебник русского языка: Теория и практика / Хян. Д.Лхагвасүрэн, Н.Энхтуяа.- УБ., 2008.- 499х.- ISBN 978-99929-883-5-5 Нийт-2ш**


Уг сурах бичигт орос хэлний бүх дүрмийг анхан шатнаас нь эхлэн гүнзгийрүүлэн дэс дараалж өгсөн билээ. Сурах бичигт өгөгдсөн материалыг хичээл болон, сургалтын шатлал болгож хувиарлаагүй ба орос хэлний янз бүрийн бэлтгэлтэй хүмүүсийг хэрэгтэй материалаа уг номноос хаанаас нь ч ашиглаж, үзэж судлахад зориулагдсан байна.



**Gantsetseg J., Dugarmaa S.**  
**English for tourism / Edited by N.Galimaa.- УБ., 155р.- ISBN 978-99929-51-75-3 Нийт-5ш**

Энэ ном нь аялал жуулчлалын мэргэжлээр сурч байгаа оюутнуудад зориулагдсан байна. Энэ номонд аялал жуулчлалын менежментийн англи нэр томъёонуудыг агуулсан дасгал ажлууд, толь бичиг, хэлү үгнүүд, текстүүдийг агуулсан байна.

**Эдийн засаг, маркетинг, менежмент:**



**Одгэрэл А.**

**Зардлын бүртгэлийн бодлогын хураамж / Ред. Б.Баярмаа.- УБ., 2008.- 124х. Нийт-2ш**

Бодлогын хураамжийг их, дээд сургуулийн багш, оюутан болон мэргэшсэн нягтлан бодогч нарт зориулагдсан ба зардлын бүртгэл хичээлийн үндсэн ойлголтуудыг судалсны үндсэн дээр ашиглах боломжтой юм.

**Эрдэнэцэцэг Ш.**

**Банк, санхүүгийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл / Хян. Д.Батжаргал.- УБ.: Хаан принтинг, 2008.- 365х.- ISBN 978-99929-55-39-2 Нийт-2ш**

Банк санхүүгийн байгууллагуудын санхүүгийн баримт бичгийн боловсруулалт, нягтлан бодох бүртгэлийн бичилт, санхүүгийн тайлан тэнцэл, бусад тайлан мэдээг гаргах аргачлал, бүртгэлээр тавих хяналт шалгалт зэргийг тэдгээрийн эрхлэн явуулдаг үйл ажиллагаа болон олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, практик үйл ажиллагаатай уялдуулан байна.



**Баярмаа Б.**

**Удирдлагын бүртгэл / Ред. Д.Баясгалан.- УБ.: Тайм принтин, 2008. 12х.х.- ISBN 99929-6-008-6 Нийт-2ш**

Удирдлагын бүртгэлийн хүрээ, түүнд холбогдох үндсэн асуудлуудын талаар онол практикийн мэдлэгтэй болоход ихээхэн ач холбогдолтой. Номын агуулга нь удирдлагын бүртгэлийн тухай, түүний зориулалт ач холбогдол, зардлын ангилал түүний зарчмууд, зардал тоо хэмжээ ангийн хамаарлын шинжилгээ, санхүүгийн тайлангийн шинжилгээ, бүтээгдэхүүний үнэ зохиолт зэрэг агуулгуудыг хамарсан байна.



**Хулан Ж., Дэлгэрмаа Б., Оюун Д.**  
**Олон улсын бизнесийн эрх зүй.- УБ.: Содпресс, 2007.- 16х.х.- ISBN 978-99929-54-12-4 Нийт-3ш**

Эдийн засаг, бизнесийн удирдлага, хууль, эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутнууд, судлаач-багш нар, бизнес эрхлэгчид, гадаад худалдаа олон улсын тээвэр зуучийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг компаний ажилчдад зориулсан болно. Хөрш орнууд болон бусад улс орны хууль тогтоомж, шүүхийн шийдвэрүүдийг жишээ болгон авсан нь бичнэс эрхлэгчдэд тустай байна.


**Саранчимэг А., Одгэрэл А.**  
**Дунд шатны нягтлан бодох бүртгэл / Ред. Ж.Жаргалсайхан.- УБ., 2005.- 606х.- ISBN 99929-5-875-6 Нийт-3ш**

Дунд шатны нягтлан бодох бүртгэл сурах бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн үндэс, Санхүүгийн бүртгэл зэрэг хичээлүүдийн үндсэн ойлголтууд дээр суурлагдсан бөгөөд олон улсын практикт өргөн ашиглагддаг бүртгэл болон тайлагналын илүү нарийн ойлголтууд, арга аргачлалуудыг авч үзэдгээрээ уншигчдад энэ чиглэлээр мэргэших боломжийг олгож байгаа юм.



**Ариунаа Л.**  
**Санхүүгийн зах зээл, банкны удирдлага: Гарын авлага / Хян. Д.Нарандэлгэр.- УБ.: Хөх судар принтинг, 2008.- 162х.- ISBN 99929-68-40-0 Нийт-1ш**

Гарын авлага нь Санхүүгийн зах зээл байгууллагын тогтолцоо, Банкны удирдлага гэсэн хоёр хэсэг, долоон бүлэгтэй. Сэдэв тус бүрийг тухайн асуудлын онолын болон бодит амьдралд хэрэгжиж буй талаар жишээ баримтаар баяжуулан тайлбарласан.



**Болормаа Д.**  
**Менежмент / Ред. Д.Гэрэлмаа.-УБ.,**  
**2008.- 258х. Нийт-5ш**

Ном нь 4 бүлэгт хуваагдсан ба эхний бүлэгт байгууллага ба удирдлагын үйл явц, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн тухай авч үзсэн бол, харилцаа холбоо, шийдвэр гаргалт, шийдвэр гаргалтын аргууд ба загваруудын тухай 2 бүлэгт оруулсан. Удирдлагын функцууд, бүлгийн динамик ба удирдлага гэсэн ойлголтуудын талаар дараагийн бүлгүүдэд


хамруулсан байна.

**Басселер У., Хайнрих Й., Утехт В.**  
**Эдийн засгийн онолын үндэс / Хян.**  
**Д.Нарандэлгэр; Орч. Л.Ариунаа.- УБ.: Хөх**  
**судар, 2008.- 295х.- ISBN 99929-68-41-9**  
**Нийт-2ш**



Макро болон микро түвшинд эдийн засгийн онолын суурь загварыг амьдрал практиктай холбон тайлбарласан, ялангуяа төрийн бодлогын хэрэгжилтийг олон жишээ баримтаар харьцуулан харуулсан нь их дээд сургуулийн суралцагчид болон эдийн засгийн бодлого боловсруулах үйл явцад оролцогчдод мэдлэг яадвараа дээшлүүлэхэд ихээхэн тус нэмэр болно.

**Барилгын Инженер. Архитектурын Сургууль**  
**12 төрлийн 566 ширхэг ном авсан**



**Мягмаржав Ч.**  
**AutoCAD 2007/2008: Бие даан судлах**  
**сурах бичиг / Ред.Д.Баттогтох, Х.Анхбаяр.- УБ.:**  
**Урлах эрдэм, 2008.- 250х.-**  
**ISBN 978-3-057-8 Нийт-48ш**

Autocad програм ашиглан зураг зурах, засварлах, текст бичих, зурааслах, гурван хэмжээст загвар үүсгэх, түүнийг янз бүрийн байдлаар харах, ажлын хуудас ҮҮсгэх, хэвлэх, тохиргоо хийх ажиллагааг тодорхой жишээн дээр тайлбарласан. AutoCAD програмыг эхлэн болон гүнзгийрүүлэн судлаж байгаа нийт хүмүүст зориулагдсан байна.



**Алтангэрэл С.ба бус.**

**Микро эдийн засгийн ухаан: Сурах бичиг / С.Алтангэрэл, Б.Нацагдорж, Б.Сарангэрэл.- УБ.: Сорхон цагаан ХХК, 2008.- 284 х.- 99929-72-15-7 Нийт-29ш**

Микро эдийн засгийн үндсэн асуудлуудыг цогц байдлаар тусгаж Монгол ахуйд тохирсон жишээ, баримтыг өргөн ашигласан байна. Сэдэв бүрийн эцэст холбогдох сорил, бодлого, дасгалыг оруулж өгсөн.

**Алтангэрэл С.ба бус.**

**Макро эдийн засгийн ухаан: Сурах бичиг / С.Алтангэрэл, Б.Нацагдорж, Б.Сарангэрэл.- УБ.: Сорхон цагаан ХХК, 2008.- 366 х.- ISBN 99929-72-14-9 Нийт-29ш**

Макро эдийн засгийн үндсэн ойлголтууд болох инфляци, зах зээл түүний тэнцвэр, ажилгүйдэл, эрэлт нийлүүлэлт, эдийн засгийн өсөлт, гадаад худалдаа олон улсын эдийн засгийн харилцааны тухай өргөн авч үзжээ. Онол, практик, сорил, бодлого, дасгалыг оруулсан байна.



*КТМС-20ш, БИАС-20ш*



**Тэгшжаргал Н.**

**Шинэ зууны оюутан / Хянан тохиолд. П.Эрдэнэбат.- УБ., 2008.- 254х.- ISBN 978-99929-1-401-7**

Улс орны зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаа мэдээллийн эрин болох өнөө үед шинэчлэл, дэвшлийн үндэс, баталгаа нь иргэдийн болосрол. 16-22 насны залуус өөрийнхөө физиологи, оюун ухаан, сэтгэл зүйн нөөц боломжоо танин мэдэж өөрийгөө нээх, өөрийнхөө оюуны чадамжаа хэрхэн хөгжүүлэх ажил хэрэгч бүтээлч мэргэжилтэн болох арга замын тухай энэхүү гарын авлагад зөвлөсөн байна.



**Даажав Б.**

**Монголчуудын мөнх тэнгэрийн хүчин дор ивээгдэн амьдрахуйн учир: 3 дэвтэр / Хян. Ч.Батсуурь.- УБ., 2008.- ISBN 978-99929-3-010-1 Нийт-135ш**

Зохиогч энэхүү 3 цуврал бүтээлдээ Монголын оюун сэтгэлгээний тухай болон түүх судлал, цаг хугацааны тухай монгол ойлголт, монгол хүний хөгжил, монгол ёс заншил, эзэн богд Чингис хааны монгол улсаа тохинуулсан монгол сэтгэлгээний талаар хүүхэд, залуу үе, оюутан залуустаа зориулж дэлгэрэнгүй өгүүлжээ.

Тэргүүн дэвтэр: Монголчуудын оюун сэтгэлгээний нууц.- УБ.- 49х.

Дэд дэвтэр: Монгол нүүдэл иргэншлийн нууц.- УБ.- 60х.

Гутгаар дэвтэр: Эзэн Богд Чингисийн улс тохинуулсан нууц.- УБ.- 69х.

**Батцагаан Б.**

**Гөлтгөнөн барьцалдуулагч материал ба эдлэл: Сурах бичиг / Хян. Ч.Дэндэвдорж.- УБ.: ШУТИС-ийн ХҮСТ, 2008.- 439 х.- ISBN 978-99929-51-71-0 Нийт-25ш**



Сурах бичигт гөлтгөнөн барьцалдуулагч материал эдлэл гарган авах, үйлдвэрлэх технологи түүнийг барилгын салбарт өргөн ашиглах талаар дэлгэрэнгүй тусгасан болно. Энэхүү ном нь барилгын инженерийн бүх мэргэжлийн оюутан, магистр, докторант болон барилгын материалын үйлдвэрийн инженер техникийн ажилтнуудад зориулагдсан.



**Essential english tests Intermediate / Edi.S.Dugarmaa.- УБ.: Nom khur, 2007.- 182х.- ISBN 978-99929-803-5-4 Нийт-79ш**

Англи хэлний дунд шатны тестийн ном нь дотроо 13 хичээлийн хэл зүй, дүрэм, толь бичиг, асуулт, хариултыг агуулсан болно. Англи хэлийг сурч буй нийт хүмүүст зориулагдсан.



**Гэрэлхүү Ж. ба бус.**


**Барилгын процессын технологи:  
Сурах бичиг / Ж.Гэрэлхүү, Н.Баттүвшин,  
Г.Чулуут; Ред. Ж.Гэрэлхүү.- УБ.: 2008.- 388х.-  
ISBN 99929-3-029-2 Нийт-90ш**

Сурах бичигт иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийг барих үйлдвэрлэлийн процесс, түүнийг хамгийн зохистой материал, бүтээц, эдлэлээр орчин үеийн машин техник хэрэгсэл ашиглан барих онолын үндэслэл, гүйцэтгэх аргыг тодорхой заасан байна.

Барилгын салбарт техникийн дэвшил нэвтрүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээд зэргээр ханган хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга барилыг оюутнуудад эзэмшүүлэхэд анхаарчээ.

Барилгын мэргэжлийн оюутнуудаас гадна манай орны барилга, угсралт, зураг төслийн байгууллагын инженер техникийн ажилтнуудад зориулагдсан.

**Улаанбаатар: Хотын хөгжил,  
бүтээн байгуулалт, түүхэн замнал /  
С.Мөнхжаргал, Д.Цэдэв,  
С.Лувсангомбо ба бус.; Ред.  
Ю.Жаргал.- УБ.: АДМОН, 2006.- 224х.  
Нийт-1ш**



Улаанбаатар хотын үүсэл гарвалын шаштар, их бүтээн байгуулалтын он жилүүдийн түүхэн замнал, улс орны нийгэм эдийн засаг, соёлын амьдралд болж өнгөрсөн бодит баримтад түшиглэн туурвисан эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийн утгачил, эрдэнэт хүмүүн, нийслэлийн эрин зуун дамнасан хөгжлийн тухай дэлгэрэнгүй өгүүлсэн зурагт альбом. Нүүдэлчин Монголчуудын хот байгуулалт, суурин соёл иргэншил бүхий бусад улс орны ард түмнээс ялгарах өөрийн онцлог, өвөрмөгц арга барилтай байсан хэдий ч хүн төрөлхтний нийтлэг зарчимд тулгуурлан хөгжих болтлоо урт зам туулсаныг энэхүү номноос мэдэж болно.

С. Баттөх  
ДҮРСЛЭХ ГЕОМЕТРИЙН  
БОДЛОГО, ДАСГАЛЫН  
ХУРААМЖ



**Жигжид Б.**

**Дүрслэх геометрийн бодлого, дасгалын хураамж / Ред. Д.Баттогтох.- УБ.: Урлах эрдэм, 2008.- 108х. Нийт-60ш**

Дүрслэх геометрийн бодлого бодох аргачлал, тайлбар жишээг оруулж, бодлогыг өгөгдөл дээр нь бодох боломж, нөхцлийг тооцож хавсралт болгон оруулсан. Их, дээд сургууль, коллежийн оюутанд зориулсан.

**Оюунчимэг Б.**

**Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх арга зам /Хян. Б.Даваасүрэн, Д.Очирбат.- УБ.: Мөнхийн үсэг, 2008.- 188х. Нийт-30ш**

Энэхүү номонд эдийн засгийн хөрөнгө оруулалтын онол арга зүй, удирдлага, зохион байгуулалтыг судлан тайлбарлаж ялангуяа барилгын салбарт хөрөнгө оруулалт түүний үр ашгийг дээшлүүлэх арга замыг өөрийн орны онцлог, тулгамдсан асуудлуудтай уялдуулан боловсруулсан байна.

Их, дээд сургуулийн инженер менежментийн мэргэжлийн ангийн оюутнууд, магистрант, докторант болон салбарын эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллагын ажилтнуудад зориулагдсан.



**Эрчим Хүчний Инженерийн Сургууль**  
**12 төрлийн 262 ширхэг ном, сурах бичиг авсан**



**Батмөнх С.**

**Дулаан нэвтрүүлэлт: Дулаан дамжуулалт 1 /Хян. Д.Содномдорж.- УБ.: Бемби сан ХХК, 2007.- 299х.- ISBN 978-99929-50-53-6 Нийт-40ш**

Эл ганц сэдэвт бүтээлд дулаан нэвтрүүлэлтийн үндэс, дулааны энергийн ойлголт, дулаан дамжуулалт, дулаан солилцооны механизмуудыг нарийвчлан тусгасан байна.

Мөн дулаан нэвтрүүлэлтийн бодлогыг нэг, хоёр, гурван хэмжээст гэж бүлэглэн дулаан нэвтрүүлэлтийн тэгшитгэлийг интегралчлах аргуудыг системчлэн харуулжээ.



**“Эрчим хүчний салбарын түүхэн хөгжил, ирээдүйн чиг хандлага” сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл /Ред. Д.Гягар, Т.Хишигт.- УБ.: АМЖА Printing, 2002.- 263х. Нийт-14ш**

Түлж эрчим хүчний салбарын 80-н жилийн ойд зориулагдсан “Эрчим хүчний салбарын түүхэн хөгжил, ирээдүйн чиг хандлага” сэдэвт онол практикийн бага хурлын үеэр тавигдсан илтгэлүүдийг эмхэтгэн хэвлүүлжээ.

#### Ноовой Ч.

**Уурын турбин: Сурах бичиг /Хян. Ч.Дашпунцаг.- УБ.: Бемби сан ХХК, 2008.- 166х.- ISBN 99929-77-46-9 Нийт-30ш**

Уурын турбины бүтэц, зохион байгуулалт, ажиллах зарчим, түүнд явагдах дулаан процессын онолын үндэс болон дулааны тооцоо хийх арга зүйн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

Сурах бичиг нь Дулааны цахилгаан станцын ашиглалт мэргэжлээр суралцаж байгаа нийт оюутан, магистр, доктрант болон энэ мэргэжлийг сонирхон судалж байгаа нийт хүмүүст зориулагдсан болно.



**Учебно-технический словарь общетехнической лексики / Ж.Баасандорж, Ч.Гульнара, Ч.Эрдэнэсүвд и др.- Ред. Ч.Авдай, С.Давааням, Ч.Гульнара.- Эрдэнэт.: Эрдэнэт концерн ХХК, 2001.- 203р. Нийт-22ш**

Энэхүү техникийн орос-монгол толь бичигт математик, физик, хими, эрчим хүч, инженерийн зурагзүй, онолын механикийн салбарын мэргэжлийн 10000 үг оруулсан.



**Органик бус хими: Сурах бичиг / Б.Баатарсүх, Ж.Бүдсүрэн, Б.Бямбагар ба бус.; Ред. Б.Баатарсүх, Ж.Бүдсүрэн, И.Сүхбаатар.- Хоёрдугаар хэвл.- УБ.: Бемби сан, 2006.- 488х.- ISBN 99929-50-16-1 Нийт-19ш**

Сурах бичиг нь ерөнхий хими, элементийн хими гэсэн хоёр хэсгээс бүрдэж химийн үндсэн хууль, зүй тогтол, атомын бүтэц, химийн элементүүдийн байгальд орших, түүнийг гарган авах арга, физик химийн шинж чанар, чухал нэгдлүүдийн талаар үелэх системийн бүлэг нэг бүрээр ангилан бичсэн.

**Бямбагар Б.**

**Органик хими: Сурах бичиг / Хян. М.Наранцэцэг.- Нэгдүгээр хэвл.- УБ.: Бемби сан, 2006.- 505х.- (ШУТИС МТС).- ISBN 99929-50-05-6 Нийт-10ш**

Сурах бичигт органик бодисын хими ба физикийн шинж чанар, органик химийн судлах зүйл, нэгдлүүдийн урвалын төрлүүд тэдгээрийн механизм, явагдах чиглэлийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн.



**Программчлалын хэл Си/Си++: Сурах бичиг / Т.Уранчимэг, Ж.Алимаа, Г.Уртнасан, Х.Сарангэрэл; Ред.С.Уянга.- УБ.: Аргамаг принтинг ХХК, 2005.- 162х.- ISBN 99929-0-385-6 Нийт-4ш**

Сурах бичигт программчлалын хэл Си хэл түүнтэй холбоотой жишээ программ, дасгал бодлогыг олон хувилбартайгаар оруулж өгсөн байна.

Программчлалын хэл Си болон Си хэлийг эхлэн суралцагч нийт хүмүүст болон энэ чиглэлээр хичээл заадаг багш сурган хүмүүжүүлэгч нарт зориулагдсан.



**Гидравлик аэродинамик: Сурах бичиг**  
/ Б.Жамбалдорж, Ш.Даваажамц, П.Болд ба бус.; Ред.С.Батмөнх.- УБ.: 2000., 339х.  
Нийт-4ш

Энэхүү сурах бичигт шингэний хөдөлгөөний хуулиуд, шингэн ба хатуу биеийн харилцан үйлчлэл, шингэн ба хийн кинематик, шингэний динамик, гидравликийн үзэгдлийн загварчлалын тухай дэлгэрэнгүй өгүүлжээ. Техник, технологи, механикийн мэргэжлээр Их, дээд сургуульд суралцагсадад зориулагдсан.

**Хөхөө Д., Цогбадрах Г.**

**Суралцах арга: Гарын авлага: Их, дээд сургуулийн оюутан, ахлах ангийн сурагчдад зориулав.- УБ., 2001.- 58х.  
Нийт-49ш**

Оюутан, сурагч, залуу үеийнхэнд хэрхэн суралцах арга барилыг эзэмших, мэргэжил сонгоход юу анхаарах, сургалтын системийн элементүүд, лекц, практик, лабораторын хичээлд хэрхэн суралцах талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байна.



**Мангалжалав Ч., Энхжаргал Х.**

**Сэргээгдэх эрчим хүчээр ажиллах бага оврын хөргүүр /Хян. Д.Түвшинбаатар.- УБ.: Соёмбо Printing, 2007.- 104х. Нийт-10ш**

Сэргээгдэх эрчим хүчний нөөц, нар салхины эрчим хүчийг ашиглах үндэс, малчдыг цахилгаан эрчим хүчээр хангах, нарны цахилгаан үүсгүүрийн чадлын сонголт, энергийг зөв зохистой ашиглах арга, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөг бууруулах аргуудын талаар Монголын сэргээгдэх эрчим хүчний онцлогтой холбон авч үзжээ.

Төвлөрсөн номын сан

---

**Үйлдвэрлэлийн Технологи Дизайны сургууль**  
**нийт 15 төрлийн 137 ширхэг ном авсан**




**Хэрэглээний механик 2: Сурах бичиг /**  
**Н. Төмөрбаатар, Г. Чимэд – Очир, А. Гэлгөө**  
**ба бус. -УБ., 2007.- 290х.**

Техникийн механикийн бүрэлдэхүүн хэсэг болох Материалын эсэргүүцэл, Машины эд ангийн хичээлийн үндсэн агуулгыг хамран оруулжээ. Энэхүү сурах бичиг нь их дээд сургууль, коллежид инженер технологийн чиглэлээр суралцаж байгаа оюутан болон инженер техникийн мэргэжилтэнд зориулагдсан.


**Шинжлэх Ухааны философи: Сурах**  
**бичиг .- УБ.: Адмон, 2008.-325 х. .- ISBN**  
**978-99929-0-467-4**

Шинжлэх ухааны ерөнхий зүй тогтлууд, судалгааны арга зүй, танин мэдэхүйн эмпирик ба онолын түвшин, эпистемологи, гносеологийн талаар өгүүлнэ. Байгалийн болон хүмүүнлэгийн ухааны олон салбарт сурч буй оюутан, магистр, аспирант нарт зориулагдсан.



**Өлзийсайхан Д.**  
**Монголын үндэсний сэхээтэн: Үүсэл**  
**хөгжлийн зүй тогтол, хувь тавилан / Ред.**  
**С. Төмөр-Очир. – 2 дахь хэвл.- УБ., 2007. -**  
**518х. –ISBN 99929-73-78-1**

Монголын сэхээтний үүсэл, төлөвшил, хөгжлийн түүхэн замнал, үүрэг роль, чанар, хувь тавилан нь ямар байсан зэрэг сэхээтэнтэй холбогдсон онол, практикийн олон асуудлыг тусгажээ.



**Саранчимэг Ш. Ба бус.**  
**Дөрвөлжин хээтэй даавуун хувцас загварчлах, оёх технологи: Сурах бичиг / Ш. Саранчимэг, Ц. Нямжав, Ө. Баянтуул.- Нэмж. засв. 2 дахь хэвл.- УБ., 2007.- 160 х.**

Төрөл бүрийн дөрвөлжин хээ, судалтай даавуугаар хувцас зохион бүтээх, загварчлах, эсгэх болон оёх технологийн онцлогийг нарийвлан тусгаж, үлгэрчилсэн зургаар тайлбарлан үзүүлсэн болно.

**ХЗБНА-ын үндсэн дээр төрөл бүрийн эсгүүртэй эмэгтэй хүний хавар, намрын пальтоны зохион бүтээлт: Гарын авлага.- УБ., 2008. -28х.**

Гарын авлагад ХЗБНА-ын үндсэн дээр эсгүүрийн хувьд хүндрэлтэй загварчилгааг эмэгтэй хүний хавар, намрын пальтоогоор жишээ авч харуулсан бөгөөд загвар зохион бүтээгчдийг ахисан шатны сургалтанд зориулав.



**Батсайхан Ц., Ариунболор Д.**  
**Нэхмэл эдлэлийн дизайн: Гарын авлага / Ред. Д. Алимаа.- УБ.: Хэвлэлийн Үйлдвэр Сургалтын Төв, 2008.- 104 х. – ISBN 99929-51-72-9**

Нэхмэлийн дизайны бүхий л хүрээг хамран гэр ахуйн хувцас, нэхмэлийн урлаг, нэхмэл гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн Монголд хөгжиж буй байдлыг энэхүү гарын авлагад үзүүлэхийг зорьсон. Нэхмэлийн эдлэлийн дизайны салбарын оюутнууд, дизайнер, дизайн сонирхогч хэн бүхэнд зориулсан.




**Хөнгөн аж үйлдвэр эрдэм судлал /  
Эмхт. С. Төгс.- УБ.: Цоморлиг төв, 2004.- 240  
х.**

Хөнгөн аж үйлдвэрийн салбарт ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа эрдэмтдийн үйлдвэрлэл практикт нэвтэрсэн ба нэвтрүүлэхэд бүрэн боломжтой техник технологи, эдийн засаг, удирдлагын чиглэлийн үр дүнтэй бүтээлүүдийг энэхүү эмхэтгэлд хамруулан оруулжээ.

**ХЗБНА-ын үндсэн дээр ердийн залгаа ханцуйны загварчилгаа: Гарын авлага.-УБ., 2008.-18х.**

ХЗБНА-ын үндсэн дээр 7 төрлийн ердийн залгаа ханцуйны загварчилгааг гарын авлагад эмхтгэн оруулжээ.



Алимаа Д. ба бус.

**“FLYING TIGER” сүлжих машины ажиллах зарчим / Д.Алимаа, П.Туул, Д.Биндэрья.- УБ., 2008.-112 х.**

Энэхүү номонд нь “FLYING TIGER” сүлжин машины танилцуулга, машины бүтэц зохион байгуулалт болон төрөл бүрийн хээ сүлжих арга ажиллагаа, машины засвар үйлчилгээний талаар тусгажээ. Үйлдвэрийн ажилчид, инженер техникийн ажилтнууд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, дизайнеруудад зориулагдсан. Сүлжмэлийн үйлдвэрүүдэд хэрэглэгдэж буй гар сүлжих Wild horse, Takahashi зэрэг машинууд нь Flying Tiger–тай адил зарчмаар ажилладаг тул эдгээр машинуудыг ажиллуулахдаа уг гарын авлагыг ашиглах боломжтой юм.



Алимаа Д. Ариунболор Д.  
**Сүлжмэл хувцасны зохион бүтээлт:  
Сурах бичиг / Ред. Д. Энхтуяа.-УБ., 2008.-  
187х.- ISBN 99929-51-73-7**

Сүлжмэл эдлэлийн зохион бүтээлтийн суурь үлгэр байгуулах Япон хялбар аргачлалд тулгуурлан ноос ноолууран эрэгтэй, эмэгтэй хүний болон хүүхдийн төрөл бүрийн хийц, загвартай цамц, өмд, юбоканы нэр төрөл дээр боловсруулсан зохион бүтээлтийн аргачлалыг энэхүү номонд орууллаа. Сурах бичгийг сүлжмэл болон хувцасны салбарын оюутнууд, сүлжмэлийн үйлдвэрүүдийн загвар зохион бүтээгч, дизайнеруудад мөн эхлэн суралцагчид, сонирхогчдод зориулав.

**Баянтуул Ө.**

**Хувцас зохион бүтээх онол, арга  
зүйн үндэс/ Ред. Ч. Авдай. –УБ., - 180х.**

Энэхүү номонд хүний биеийн анатоми, морфологийн үндсэн шинжүүд, Монгол хүний биеийн хэмжээ, хэв шинжит галбир, түний оцлогт тохирсон хувцас зохион бүтээх онолын үндэслэл, зохион бүтээлтийн цэгүүд ба хэрчмүүд, сулын хэмжээ, суурь үлгэр тооцоолох томъёо, байгуулах дэс дараалал, хувцасны бүрдэл хэсгийн градацийн тухай иж бүрэн материалыг эмхтгэн оруулжээ.



КТМС. УДТС



**Техникийн механикийн жишээ бодлого /  
Ред. Ч. Авдай. - УБ., 2008.- 532х.**

Энэхүү номонд онолын механик, машин механизмын онол, материалын эсэргүүцэл, машины эд ангийн хичээлүүдийн үндсэн бүлгүүдийг судлаж, чадвар дадалтай болоход нэн шаардлагатай олон тооны жишээ оруулж, бие дааж бодох бодлогуудыг хавсаргасан.



**Дамдинсүрэн Д.**  
**Хэвлэлийн технологийн үндэс / Ред.**  
**Авдай -УБ., 2007.- 367х.**

Хэвлэлийн технологич, хэвлэлийн эх бэлтгэгч, хэвлэлийн график дизайн, компьютерийн график дизайн зэрэг мэргэжилээр ИДС, коллеж, дамжаануудад бэлтгэгдэж байгаа сурагчид, оюутан залууст дахин толилуулж байгаа энэхүү нэмж завсарласан 2 дахь хэвлэлд хэвлэлийн технологийн үндсийг тусгасан.

**Дамдинсүрэн Д.**  
**Тоон хэвлэлийн технологи / Ред.**  
**Ч. Авдай.- УБ., 2006.- 342х.**

Лазерын бичиглэл ашиглан ЭФГ-дүрсийг хуулбарлах тоон арга ба технологид дээр үндэслэсэн орчин үеийн өнгөт электрофотографи буюу тоон хэвлэлийн технологийн үндсийг уншигчдад хүргэхийг зорив.



**Одмаа П.**  
**Жижиг үйлдвэрлэлийн менежмент,**  
**төсөл боловсруулах арга зүйн зөвлөмж /**  
**Ред. С.Төгс.- УБ., 2006.- 84 х.**

Үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагааг амжилттай хөгжүүлэхийн тулд зах зээл, маркетингийн судалгаанд тулгуурласан, үр ашигтай үйлдвэрлэл эрхлэх талаар болон хүний нөөцийн менежмент, бүтээгдэхүүний арилжаа, аж ахуй нэгжийн борлуулалтын орлого, ашгийн тооцоо, үйлдвэрлэлийн төсөл тооцоо боловсруулах чиглэлийн талаар тодорхой арга зүй эзэмшихэд тус дэм болно.

**Механик Инженерийн Сургууль**  
**нийт 15 төрлийн 76 ширхэг ном авсан**

КТМС, МИС,ХМТС



**Хүрэлжанцан Д.**

**Монгол угсаатны гал голомт. Мандал  
буурлын хураангуй.- УБ., 2008.- 138х.-  
ISBN 978-99929-4-208-8**

Энэхүү номонд бидний гал голомт, өнөөгийн Монгол Улсын нутагт Хүннү хэмээх нүүдэлчний анхны хүчирхэг төрт улс үүссэн хөгжлийн түүхийг хүүрнэжээ. Монгол угсаатны түүхийн энэхүү ном нь нийт уншигчдад зориулагджээ.

**Хууль зүйн ширээний ном /Эмхт.  
Ж.Лхагвасүрэн.- УБ., 2008.- 256х.-  
ISBN 978-99929-827-6-4.**

